

“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОЛЦОО” СЭДЭВТ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Аялал жуулчлалын салбарт агаарын тээврийн үзүүлэх нөлөө, үр өгөөжийг нэмэгдүүлэх, орон нутгийн нисэх буудлуудын зорчигч үйлчилгээг сайжруулах, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хамтран хөгжүүлэх зорилгоор “Жуулчинд ээлтэй нисэх буудал” уриан дор зохион байгуулсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд агаарын тээврийн оролцоо” зөвлөгөөнд оролцогчид нь дараах Зөвлөмжийг гаргаж, хэрэгжүүлэхийг уриалж байна. Үүнд:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам

- Орон нутгийн нисэх буудлуудыг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлэн, өргөжүүлэх нь агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцогч бүх талуудад нэн тэргүүний ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгасан Дорнод, Өмнөговь, Ховд, Увс, Завхан, Хөвсгөл аймгуудыг 4С зэрэглэлийн аэродромуудтай болгож, өргөтгөн, олон улсын статус бүхий зорчигч үйлчилгээний цогцолбортой нисэх буудал болгох зорилтыг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөө гаргах;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Ховд, Дорнод, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудыг 4 С ангиллын аэродромтой олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, бүтээн байгуулалтыг эхлүүлэх;
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих замаар орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулах;
- Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд агаарын тээвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, агаарын тээврийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог дэмжих, татвар, татаасын бодлогыг төрөөс хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

Хоёр. Иргэний нисэхийн ерөнхий газар

- Нисэх буудалд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, аялагч, зорчигчдын аюулгүй байдлыг хангах контактгүй үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой шинэ техник технологи нэвтрүүлэх хэрэгжүүлэх;

Гурав. Иргэний нисэхийн үндэсний төв, Аялал жуулчлалын хөгжлийн төв

- Орон нутгийн нисэх буудлуудад жуулчинд чиглэсэн мэдээллийн технологийн шинэ чиг хандлагыг судлан хэрэгжүүлэх;

- Орон нутгийн нисэх буудлын ажилтнуудад үйлчилгээний болон англи хэлний сургалт зохион байгуулах;
- Орон нутагт аялал жуулчлалын мэдээллийн төв байгуулахад хамтран ажиллах;
- Орон нутгийн нисэх буудлуудад Ковид-19 цар тахлын эсрэг халдвар хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын зөвлөлийн Нисэхийн салбарын үйл ажиллагааг дахин сэргээх ажлын хэсэг (CART)-ийн гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх сургалт явуулах, холбогдох дүрэм, журам боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
- Аюулгүй аяллын удирдамж хэрэгжүүлэхдээ холбогдох эрүүл мэнд, ариутгал халдваргүйтгэл, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын хэрэгжүүлж буй дүрэм, журмуудтай уялдуулах;
- Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Аюулгүй аяллын шошго олгох ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх.

Дөрөв. Орон нутгийн нисэх буудлууд

- Нисэх буудлын нисэхийн бус орлого олох шинэ боломжуудыг судлах, тухайн орон нутгийн түүх соёлын шинж чанарыг агуулсан жижиг, дунд үйлдвэрийн бренд бүтээгдэхүүний худалдааг нисэх буудал дээр зохион байгуулах;
- Инноваци, технологийн дэвшлийг ашиглан нисэх буудлын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах, тэдгээрийн өөрчлөгдөн нэмэгдэж буй хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх;
- “Жуулчинд ээлтэй нисэх буудал” зорилгын хүрээнд орон нутгийн онцлогт тохирсон шинэ санал, санаачилга гарган хэрэгжүүлэх, ажилтан, хувь хүний ийм төрлийн санаачлагыг дэмжих;
- Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын Аюулгүй аяллын удирдамжийг хэрэгжүүлэх, Аюулгүй аяллын шошго авах.

**“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХЭД АГААРЫН ТЭЭВРИЙН
ОРОЛЦОО” СЭДЭВТ ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГЧИД**